


**“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн
М.Батжаргалын 2023 оны сүүлийн хагас жилийн ажлын тайлан**

Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль, Монголбанкнаас баталсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Төрийн банкны дүрмийн дагуу хараат бус гишүүний үүргээ гүйцэтгэн ажилласан. 2023 оны сүүлийн хагас жилийн байдлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд 5 удаа оролцож, хэлэлцсэн асуудлыг шийдвэрлэхэд өөрийн санал дүгнэлтээ өгч ажилласан.

Тайлант хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Төрийн банкны 2024-2026 оны Стратеги төлөвлөгөө, 2024 оны Бизнес төлөвлөгөө, 2024 оны Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний саналтай танилцан, баталсан.
- Төрийн банкны үйл ажиллагааны 2023 оны 2,3 дугаар улирлын тайлан, Төрийн банкны мөнгө- угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны 2,3 дугаар улирлын тайлантай танилцан үүрэг даалгавар өгч ажилласан.
- Төрийн банкны 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх гэрээг Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-тай байгуулах асуудлыг дэмжсэн.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор өгсөн үүрэг даалгаврын биелэлттэй танилцан ажилласан.
- Төрийн банк ХК-ийн хувьцааг нэмж гаргах ажлын явцтай танилцан, санал өгч ажилласан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хуралд 6 удаа оролцсон. Дотоод аудитын газраас хийсэн аудитын ажлын тайлан, хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлттэй танилцан, санал, үүрэг даалгавар өгч ажилласан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурьтай байгаагүй бөгөөд санал дүгнэлтээ хараат бусаар гарган ажилласан.
- Их хэмжээний хэлцэл Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулагдаагүй. Хөгжлийн банкны эзэмшиж байгаа Эрдэнэс таван толгой ХК-ийн бонд худалдан авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцэл хэлэлцэн санал өгсөн.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, Цалин урамшууллын хорооны дарга, Аудит хороо болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр томилогдон ажилласан бөгөөд зохион байгуулагдсан бүх хуралд оролцсон.

Тайлан бичсэн:  ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Батжаргал